**МОНГОЛ УЛСЫН**
**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН**
**ХАМГААЛЛЫН САЙДЫН**
**ТУШААЛ**

2025 оны 09 сарын 12 өдөр Дугаар А/175 Улаанбаатар хот

**Хөтөлбөрийн төсвийн хуваарь**
**шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв батлах тухай" 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/83 дугаар тушаалаар баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын хөтөлбөрийн арга хэмжээ, зардлын төсвийн хуваарийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүлийн бодлогын газар (Ц.Мөнхзул), Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газар (Ж.Энхтөр)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхзул)-д даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсан өдрөөс эхлэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/83 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Т.АУБАКИР

D: 2025 on 09 sar tushaal

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 09 сарын 12 өдрийн А/175 дугаар тушаалын Хавсралт

ATA12744 9132155 9024070603

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨРИЙН АРГА ХЭМЖЭЭ, ЗАРДЛЫН ТӨСВИЙН ХУВААРЬ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл | Багц | Багцын даалгавар | Төсөв /сая,төгрөгөөр/ | Хариуцах нэгж | Хамтран ажиллах байгууллага | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах | 1.1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын албан хаагчдын сургалтын хэрэгцээг тандан судалж, сургалтын цахим модуль төлөвлөгөө боловсруулах, | 50.0 | ГББГ-ХБХХХ | ХБХХЕГ ТББ | Салбарын албан хаагчдын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлага нэмэгдэж, хүний эрхийн мэдрэмжтэй болно. |
| | | 1.2 | Яам болон харьяа байгууллагуудын албан хаагчдын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, чадавхжуулах сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулах | 90.0 | | | |
| 2 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх хууль эрх зүйн орчныг сайжруулах асуудлаар уулзалт, хэлэлцүүлэг нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | 2.1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хөгжил оролцоог дэмжихэд чиглэсэн хууль тогтоомжийн талаар олон нийт, аж ахуй нэгж байгууллагуудийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, зөв хандлагыг олон нийтэд сурталчлах, видео контент бэлтгэх, гарын авлага боловсруулах нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | 70.0 | ГББГ-ХБХХХ | ХБХХЕГ ТББ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний гэр бүлийнхэн хууль, эрх зүйн талаарх ойлголт мэдээлэлтэй болно, иргэд, олон нийт, аж ахуй нэгж байгууллагуудын оролцоо нэмэгдэнэ. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийг сайжруулах | 3.1 | ГБХНХЯ-ны дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийг сайжруулах | 110.0 | ГББГ-ХБХХХ | ХБХХЕГ ТББ | -Дэд бүтэц, мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ. |
| | | 3.2 | Яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр хүргэх зорилгоор вэб сайт, пэйж хуудсанд хүртээмжийн үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах , хүртээмжийг сайжруулах | 30.0 | | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд аливаа мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр авах боломж бүрдэнэ. |
| | | 3.3 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Эрүүл мэнд, шүүх, хууль, цагдаагийн байгууллагаар үйлчилгээ авахдаа мэдээллийн хүртээмжтэй байдаг эсэхэд судалгаа хийх, хамтран ажиллах | 10.0 | ГББГ-ХБХХХ | ХБХХЕГ ТББ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд шаардлагатай үйлчилгээг авахад хүртээмжтэй болно. |
| 4 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | 4.1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн арга хэмжээг зохион байгуулах | 140.0 | ГББГ-ХБХХХ | ХБХХЕГ ТББ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ. |
| | | 4.2 | -Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүртээмжтэй загвар ажлыг байрыг бий болгох, олон нийтэд таниулах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | 110.0 | | | |
| 5 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний Олон Улсын тэмдэглэлт өдөрт | 5.1 | Сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрхийн өдөрт зориулсан арга хэмжээ (2025.09.07) | 10.0 | ГББГ-ХБХХХ | ХБХХЕГ ХБИХЭДТ ТББ | Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх нөлөөллийн арга |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зориулсан нөлөөллийн арга хэмжээ | 5.2 | Цагаан таягтны өдөрт зориулсан арга хэмжээ (2025.10.15) | 10.0 | | | хэмжээг тогтмол зохион байгуулна. |
| | | 5.3 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдөрт зориулсан арга хэмжээ (2025.12.03) | 50.0 | | | |
| 6 | Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах, үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг үзүүлэх талаарх гарын авлага, видео контент бэлтгэх | 6.1 | Хараны бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх арга зүйн гарын авлага бэлтгэх боловсруулах, хэвлэх | 10.0 | ГББГ-ХБХХХ | ТББ | Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний чанар сайжирна. |
| | | 6.2 | Даунтай хүнд үйлчилгээ үзүүлэх арга зүйн гарын авлага боловсруулах | 10.0 | ГББГ-ХБХХХ | ТББ | |
| | | 6.3 | Аутизмын хүрээний эмгэгтэй хүнд үйлчилгээ үзүүлэх арга зүйн гарын авлага боловсруулах, хэвлэх | 10.0 | ГББГ-ХБХХХ | ТББ | |
| | | 6.4 | Сонсголын бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх арга зүйн гарын авлага боловсруулах, хэвлэх | 10.0 | ГББГ-ХБХХХ | ТББ | |
| | | 6.5 | Хөдөлгөөний бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх арга зүйн гарын авлага боловсруулах, хэвлэх | 10.0 | ГББГ-ХБХХХ | ТББ | |
| | | 6.6 | Суралцахуйн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх арга зүйн гарын авлага боловсруулах, хэвлэх | 10.0 | ГББГ-ХБХХХ | ТББ | |
| | | 6.7 | Ажил олгогчдод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт хандлагын сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, гарын авлага, видео контент бэлтгэх | 65.0 | ГББГ-ХБХХХ | ХБХХЕГ ТББ | Ажил олгогч байгууллагуудын ойлголт хандлага нэмэгдэнэ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 6.8 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэх зураглал турших, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах | 20.0 | ГББГ-ХБХХХ | ХБХХЕГ ХБИХЭДТ ТББ | |
| 7 | Үйлдлийн олон улсын ангилал /ICF/-ыг нийгмийн үйлчилгээнд ашиглах аргачлал, зөвлөмж | 7.1 | Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсролын, нийгмийн хамгааллын салбарын комиссын ажиллаж байгаа өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийг ICF-т нийцүүлэх талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах | 20.0 | ГББГ-ХБХХХ НДХСБГ | ХБХХЕГ ХБИХЭДТ ТББ | Хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардлагатай үйлчилгээний хэрэгцээг тодорхойлоход Үйлдлийн олон улсын ангилал /ICF/-ыг ашиглах талаар аргачлалтай болно. |
| | | 7.2 | ICF-ыг нэврүүлж нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд ашиглах, турших талаар зөвлөмж боловсруулах | 20.0 | | | |
| 8 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 8.1 | Хүүхэд, залуучуудад урлаг, соёл, спортоор дамжуулан хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтийг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээ | 60.0 | ГББГ-ХБХХХ | ХБХХЕГ ТББ | Бага насны хүүхдүүдийн Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт нэмэгдэнэ. |
| 9 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар судалгаа хийх, түүнийг бодлогод ашиглах асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах | 9.1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэлтэй гэр бүл, асран хамгаалагчийн амьдралын чанар”-ын судалгаа хийх | 19,200.0 | ГББГ-ХБХХХ | ХБХХЕГ ТББ | Асран хамгаалагчийн амьдралын чанар сайжирна. |
| | | | **Нийт** | **944,200.0** | | | |